

РУЗВЕЛЬТ БА АНУ БНМАУ-ЫН СТАТУС-КВО ХҮҮЭЭН ЗӨВШӨӨРСӨН НЬ

Доктор (D.Sc) М.Хурметхан
ШУА, Олон Улс Судлалын Хүрээлэн

Рузвельт Франклин Делано /1882-1945/ нь 1932 онд АН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж, БНН-ын Гувөртэй өрсөлдөж ялалт байгуулсан байна. Улмаар 1936, 1940, 1944 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр дахин сонгогдож байснаараа америкийн түүхэнд хамгийн олон удаа сонгогдсон ерөнхийлөгч болсон байна. Судлаачид Ф. Рузвельтийг АНУ-ын гадаад бодлогод хамгийн уян хатан зарчим баримталсан хүн гэж үздэг ажээ. Түүний гадаад бодлого үйл ажиллагааны нэгэн чухал чиглэл нь Ази-төв рүү хандсан бодлого, үйл ажиллагаа байв.

Ялангуяа АНУ, Япон, Хятадын асуудалд ихээхэн анхаарал хандуулж байсан юм.¹

Харин Монгол улсыг АНУ-ын зүгээс сонирхож судлах, мэдэх, албан ба албан бус харилцаа тогтоох талаар зарим алхам хийж ирсэн бол, Дэлхийн II дайны төгсгөлийн шатанд Алс Дорнод дахь Японы эсрэг ажиллагаанд ЗХУ-ыг оролцуулах асуудалтай холбогдон БНМАУ-ын дайны дараах олон улсын статусын асуудал яригдаж эхэлсэнээр, уг асуудалд АНУ голлох үүрэгтэй оролцох болсон байна. Энэхүү асуудлыг тухайн цаг үеийн олон улсын харилцааны байдал, АНУ-ын Ази дахь бодлого, БНМАУ-ын үндэсний эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэхэд тэр үеийн АНУ-ын ерөнхийлөгч Ф. Рузвельт жинтэй хувь нэмэр оруулсныг түүх мэдэх билээ.

Ф. Рузвельтийн Монголын талаархи үзэл бодол бүрэлдэн тогтоход АНУ-ын 26 дахь Ерөнхийлөгч /1907-1909/ Theodore Roosevelt /1858-1924/ нь нөлөөлж байв. Учир нь Ф. Рузвельт түүнийг 5 дахь үеийн бол ах дүү хүн байжээ. Харин Th. Roosevelt нь өөрийн найз, Ази судлагч J. Sillimitt "The Mongols: a history" номонд бичсэн өмнөх үгэндээ "... a full knowledge of the history of the mongol people is imprecatively necessary to all who won't understand the development of Asia and Eastern Europe"² хэмээн тэмдэглэж байжээ. Чухамдаа, энэхүү үзэл санааг Ф. Рузвельт уншиж, танилцаж байсан

нь гарцаагүй бөгөөд түүний Монголын талаархи үзэл санаа, улс төрийн бодлого тодорхойлоход чухал нөлөө үзүүлсэн гэж болно. БНМАУ-ын олон улсын статусын асуудлыг 1943 оны 11-р сард Кайрт болсон их гурнуудийн удирдагчдын уулзалт дээр Чан Кайши сөхөрт тавьсан гэж үздэг ажээ. Тэрвээр АНУ-ын ерөнхийлөгч Рузвельтэд хандан "БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах" хүсэлтийг тавьсан боловч Ф. Рузвельт энэ асуудлыг ЗХУ-тай ярилцаж шийдэхгүй бол болохгүй гэж шалтгалан хойш тавьсан байна.²

Ийнхүү АНУ-ын ерөнхийлөгч Ф. Рузвельт уг асуудалд нухацтай хандсан нь хэд хэдэн шалтгаантай болох нь мэдээж юм. Үүнд:

Нэгдүгээрт: Тэр үед АНУ-ын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан боловч төр улсынх нь хувьд эрс эсэргүүцэн, ор тас үгүйсгэж байгаагүйтэй шууд холбоотой байв.

Хоёрдугаарт: АНУ БНМАУ-ыг зөвлөлтийн дагуул орон хэмээсэн янзтай үзэл баримтлал нь БНМАУ-ын бодит байдлыг нарийн тусгаж, түүнд хандах АНУ-ын гадаад бодлогын нэгэн өвөрмөц хувилбар байв. Өөрөөр хэлбэл, БНМАУ нь ЗХУ-ын нөлөөнд гүнзгий орсон, гэхдээ БНМАУ-ыг жирийн дагуул улс хэмээн үзэж байсантай холбоотой юм.

Гуравдугаарт: АНУ БНМАУ-ыг хараанаасаа гадна байлгасангүй, харин асуудал дээр алсын бодол, зорилго, зорилттой, урьдах бодлогоо эрс өөрчилсөнтэй;

Дөрөвдүгээрт: АНУ ЗХУ-ын хувьд баримталж байсан бодлого, үйл ажиллагааны хүрээнд ЗХУ-ын БНМАУ дахь нөлөөг буруушаахгүй, түүгээр дамжуулан АНУ ЗХУ-тай ямар харилцаатай байсан, тэр өнгөөрөө БНМАУ-д хандаж байсантай;

Тавдугаарт: ЗХУ Японы эсрэг дайнд цэргээ оруулах гол бодлогын нэг болгож өөрийн нөлөөний хүрээнд дэх БНМАУ-ын тусгаар тогтнолыг бүрэн дүүрэн хүлээлтэн зөвшөөрүүлэх асуудал тавих нь нилээд эрт тодорхой болж байсантай;

Зургаадугаарт: Дэлхийн II дайны төгсгөл ойртож, Алс Дорнодод Японы милитаризмыг хамтын хүчээр бут цохих асуудал Холбоотон гурван гүрний дээд удирдлагын түвшинд 1944 оны эхэн, дунд үеэс тавигдах болсоны дотор БНМАУ-ын асуудал ноцтой хөндөгдөх болжээ.

Энэ үед АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельт дэд Ерөнхийлөгч Х.Уоллесээ Азийн орнууд, түүний дотор БНМАУ-д айлчлуулжээ. АНУ-ын дэд ерөнхийлөгч Г.А.Уоллес 1944 оны 7-р сард Монголд айлчилж, бодит байдалтай танилцаж, Монголын удирдагчидтай уулзан ярилцаж сайхан сэтгэгдэлтэй бүцсэн нь АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельтийн БНМАУ-ын талаархи ойлголт, бодлогод зохих нөлөө үзүүлжээ. Г.А.Уоллес "Гадаад Монголд эрүүл саруул дэвшил хөгжил, байлдааны бэлэн байдал, үндэсээрхэг үзэл мэдэгдэж байна.

... Улс төр ба засаг захиргааны эрх мэдэл, хяналт шалгалт чадварлаг монголчуудын гарт байна. Хятадын аливаа санаа биелэлээ олохгүй байна.⁵ хэмээн хийсэн дүгнэлтийг АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельт нэгэн адил хуваалцаж байсныг үйл явдлын өрнөл нотлон харуулсан билээ.

Японы эсрэг дайнд Зөвлөлтийн цэргийг оруулах асуудалтай хамт БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай асуудал 1944 оны сүүлчийн саруудад нэгэнт хурцаар тавигдах болж байв. 1944 оны 12-р сарын 15-нд Москва дахь АНУ-ын Элчин сайд А.Гарриманаас ерөнхийлөгч Рузвельтэд явуулсан илгээлтдээ: "Урьд шөнө би Сталинтай ярихдаа 10-р сард түүний дурдаж байсан улс төрийн ямар асуудлуудыг Орос улс Японы эсрэг дайнд орохтой холбогдуулан тавих тухай таны зүгээс мэдэхийг чухалчилан хүсэж байгааг хэлсэн юм.

Тэрээр, Тегеранд дурдаагүй ганц зүйл бол Гадаад Монголын Бүгд Найрамдах Улсыг тусгаар тогтносон этгээд гэж үзэж Гадаад Монголын Status quo-г хүлээн зөвшөөрөх явдал юм гэж хэлэв.⁶ Сталин АНУ-ын элчин сайд А.Гарримантай 1944 оны 10-р сарын 15-нд уулзахдаа "БНМАУ-ын status quo-г хадгалах гэдэг нь Гадаад Монголыг бие даасан субъектын хувьд байлгахыг хэлж байгаа юм."⁷ гэж Ялтын бага хурлын бэлтгэл ажлын үеэр мэдэгджээ. Ялтын бага хурлын үеэр 1945 оны 2-р сарын 8-нд Сталин Ф.Рузвельтээс "Гадаад Монголын Status quo-г хадгалах асуудлыг хэрхэн үзэж байна вэ?" гэж шууд асуужээ. АНУ-ын ерөнхийлөгч уг асуултанд хариулахдаа "Чан Кайшигтай зөвлөлдөж амжаагүй, гэвч Гадаад Монголын статус квог хэвээр хадгалах нь зүйтэй гэж бодож байна."⁸ гэсэн ажээ.

1945 оны 2-р сарын 11-ний өдөр гурван гүрний Крымын

хэлэлцээрт заахдаа: "Гурван Их гүрэн ЗХУ, АНУ, Их Британий удирдагчид Европт дайн дууссанаас хойш хоёр гурван сар өнгөрмөгц холбоотнуудын талд Японы эсрэг ЗХУ дор дурдсан нөхцөл болзлыг хангавал дайнд орох тухай харилцан тохиров. Үнд:

1. Гадаад Монголын /БНМАУ-ын/ статус квог /оршин тогтнож байгаа байдлыг/ хэвээр хадгалах¹⁰ гэж заахад Сталины хамт АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн хүчин чармайлт онцгой чухал үүрэгтэй байжээ.

Түүгээр ч зогсохгүй БНМАУ-ын асуудлаар Хятадын Засгийн газар Чан Кайшигийн зөвшөөрөл хэрэгтэй байсан тул Сталины санал болгосноор АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт өөрийн биеэр уг асуудлаар Чанкай Чи-тэй ярьж, түүнийг зөвшөөрүүлэх үүргийг өөртөө авчээ.¹¹

БНМАУ-ын тусгаар тогтнолыг урьд нь ЗХУ-аас өөр хүлээн зөвшөөрсөн улс байгаагүй бол 1945 оны 2 сард Крымын хэлэлцээрээр АНУ, Их Британийн хамт бас хүлээн зөвшөөрч, БНМАУ нь холбоотон гурван их гүрнээр хүлээн зөвшөөрөгдсөн нь БНМАУ-ын хүн амын цаашдын амьдрал хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд АНУ-ын засгийн газар, АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн өмнө Крымын бага хурал дээр авсан үүргийнхээ дагуу Чан Кайшигтай ярилцан, түүгээр БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх асуудал тулгарсан байна. 1945 оны 5-р сарын эхээр АНУ-ын засгийн газар Крымын хэлэлцээрийн нууц байсан эхийг Хятадын засгийн газарт албан ёсоор шилжүүлэн өгчээ. Чан Кайшийнхан БНМАУ-ын асуудал хэлэлцэхээс эрс татгалзан эсэргүүцэж, Сталинд Гадаад Явдлын Яамны сайдаараа дамжуулан тусгай захидал бичиж хүргүүлжээ.

БНМАУ-ын статус-квогийн асуудлаар Зөвлөлт-Хятадын хэлэлцээг явуулж уг асуудлыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэхэд Ялтын гэрээ, ялангуяа, БНМАУ-ын статус-квог хадгалах талаархи АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн байр суурь, гэрээнд гарын үсэг зурсан нь ЗХУ, БНМАУ-ын аль алины хувьд үнэнхүү чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Бүр Сталин хүртэл хятадын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж, БНМАУ-ын статус квог хүлээн зөвшөөрүүлэхийг

М.Хурмэгхан

"Рузвельт ба АНУ БНМАУ-ын Статус-Квог хүлээн зөвшөөрсөн нь"

М.Хурмэгхан

"Рузвельт ба АНУ БНМАУ-ын Статус-Квог хүлээн зөвшөөрсөн нь"

чармайхдаа "Энэ баримт бичиг манай хэлэлцээний үндэс болох ёстой. Ф.Рузвельт гарын үсгээ зурсан юм шүү" хэмээн мэдэгдэж, АНУ-ын ерөнхийлөгчийн өндөр нэр хүндийг онцлон дурдаж байжээ. БНМАУ-ын статус-квог хадгалах талаархи зөвлөлтийн удирдлага, ялангуяа, Сталины байр суурийг тун хатуу бүрэн ойлгосон хятадын тал, өөрийн байр сууриа АНУ-аар дэмжүүлэхийг оролдож үзсэн байна.

Түүнд, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Бирнс БНМАУ-ын статус-квогийн талаархи АНУ-ын засгийн газрын байр суурийг тайлбарлахдаа, "Ялтын гэрээний зүйл ангийг нарийн хэлэлцээгүйг дурдан, Ялтын гэрээний зүйл ангийг албан ёсоор ганцаар дур мэдэн тайлбарлах аргагүйг Учиргаад" хууль эрхийн үүднээс Гадаад Монголын бүрэн эрх /суверенитет/ Хятадад байж болох боловч, үнэн хэрэгтээ энэ нь хэрэгжих бололцоогүй зүйл юм"¹² хэмээн БНМАУ-ын статус-квог хадгалах байр суурийг нотолжээ.

АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт нь БНМАУ-ын статус-квогийн асуудлаар Чан Кайшигтай ярилцах боломж гараагүй бөгөөд Европт Дэлхийн II дайн дуусахаас өмнө учир битүүлэг шалтгаанаар нас эцэслсэн байна.

АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн БНМАУ-ын статус-квог хадгалах талаархи байр суурь Улам батжин, Зөвлөлт-Хятадын төлөөлөгчдийн хэлэлцээний эцэст БНМАУ-д бүх нийтийн санал хураалт явуулсны дараа Хятадын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрч байгаагаа 1946 оны 1-р сарын 5-нд мэдэгдсэн билээ.

Ялтын гэрээнд тусгагдсан "БНМАУ-ын статус-квогийн" тухай заалт нь БНМАУ-ын цаашдын оршин тогтнох, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх замыг нээж өгсөн туйлын чухал заалт болсон билээ. Энэ нь БНМАУ-ын олон улсын эрхзүйн субьект байгааг хүлээн зөвшөөрсөн олон улсын анхны гэрээ бичиг байлаа.

Ийнхүү АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн БНМАУ-ын статус-квог хадгалах талаар бодит байр суурь баримтлах болсны уг үндэс нь АНУ-ын засгийн газрын Ази дахь эрх ашиг стратегийн бодлого, тухайн цаг үеийн дэлхийн улс гүрнүүдийн хүчний тэнцвэрт тулгуурлан Монголын засгийн газар, ард түмний хүсэл зоригийг хүндэтгэн БНМАУ-ын статус-квог хадгалах нь чухал гэдгийг гүнзгий ойлгон, монголын ард түмний язгуур эрх ашигт нийцсэн түүхэн

шийдвэр гаргахад жинтэй хувь нэмэр оруулсан түүний гавьяат монголын ард түмэн дурсан санасаар байх болно. Тийнхүү АНУ Монгол улсыг анх хүлээн зөвшөөрснөөс хойш 56 жил өнгөрөхдөө энэхүү байр сууринаас няцаагүй бөгөөд Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт, бие даасан байдал бүрмөсөн сэргэн мандаж батжин бэхжихэд түүний гарцаагүй чухал гадаад түшиг тулгуурын нэг нь болсон билээ.

Ишлэл, зүүлт:

1. Jerald A. Combs. The History of American Foreign Policy. New York, 1986. Pp. 280-289, 294-311
2. Theodore Roosevelt 1907. Foreward /XVI/ in J. Curtin, 1972. The Mongols: a history. Greenwood Press, westport.
3. Foreign Relations of the United States Diplomatic Papers. The conference at Cairo and Tehran 6 1943-Wash. 1961. pp. 325, 326, 367
4. Н.Ишжамц "АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа /1900-1987/ Улаанбаатар, 1999.Х."
5. М.Хурметхан. Монгол улс, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа / 1945-1999/ УБ, 2000.х. 18
6. Foreign Relations of the United States Diplomatic Papers 6 The conference at Cairo and Tehran. 1943-Wash. 1961. pp. 379
7. Ц.Батбаяр. Монгол ба Япон XX зууны эхэн хагаст. УБ., 1998.х. 173
8. Мөн тэнд х. 174
9. СССР на международных конференциях период Великой Отечественной войны 1941-1945 гг. Крымская Конференция руководителем трех союзных держав-СССР, США и Великобритании. И-11 февраля 1945г. Сборник документов-М., 1984.м.ч.-с., 130
10. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхэтгэл, 1 боть. 278-279
11. СССР на международных...с. 130
12. American Diplomatic Documents. Vol. VII, Washington, 1945.p.202